**СҮХБААТАР ДҮҮРГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 26 өдөр Дугаар 02/16 Улаанбаатар хот

# Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай 13 дугаар зүйлийг тус тус үндэслэн Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

3.Газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг дарга (М.Алтангэрэл)-д ДААЛГАХ нь:

3.1.Газрын тухай хууль тогтоомжийг баримтлан дүүргийн Газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих

3.2.Дүүргийн газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хагас бүтэн жилээр тайлагнаж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд танилцуулах

ДАРГА Х.НЯМДАГВА

1140100046

Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02/16 дугаар тогтоолын хавсралт

# СҮХБААТАР ДҮҮРГИЙН 2024 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

## НЭГ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

| Д/д | Хэрэгжүүлэх ажил | Хариуцах байгууллага | Хугацаа | Төлөвлөгөөнд тусгах үндэслэл |
|---|---|---|---|---|
| | **Нэг. Хууль эрх зүйн хүрээнд хийгдэх ажил** | | | |
| 1. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолын холбогдох хэсэг /Баянгол дүүрэг, Баянзүрх дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Хан-Уул дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах/-т өөрчлөлт оруулсан тогтоолт нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах | НЗДТГ, НГЗБА, НХБХГ, УСУГ | I-IV улиралд | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан зарим хил нь олон жил суурьшин амьдарч буй иргэдийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн газартай давхацсан, зарим хэсэгт тогтоолд авах шаардлагагүй газруудыг хамааруулсан зэргээс шалтгаалан тогтоолын хэрэгжилтийг хангах, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагаанд хүндрэл учирч, Монгол Улсын Усны тухай хуулийн 22 дугаар зүйл дэх заалтууд бүрэн хэрэгжиж чадахгүй байгаа тул тогтоолыг өөрчлөх шаардлагатай болсон; |
| | **Хоёр. Газрын менежмент, төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх ажил** | | | |
| 2. | Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах | НЗДТГ, НГЗБА, НХБХГ, ДГЗБА | I-IV улиралд | Монгол улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө”, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.1 дэх заалт; |
| 3. | Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоох, нэмэлт өөрчлөлт оруулах холбогдох шийдвэрийг гаргуулан бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллах | НЗДТГ, ЗАА, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Зорилт 2.5, 9.2 дах заалт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.1 дэх заалт; |
| 4. | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг ил тод болгох, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Газрын бирж"-ийн цахим систем (www.mle.mn)-ийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 23.2.7 "Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Газрын биржийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах" дах заалт; Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 152 дугаар тогтоол; |
| 5. | Газрын нөөц санг бүрдүүлэх, газрын дуудлага худалдааны үйл ажиллагааны зардал, газар чөлөөлөх нөхөх олговрын хөрөнгө, газрын нөөц санг бий болгох зорилгоор газар хөгжүүлэх санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг цуглуулах, мэдээллийн санд бүртгэх | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/219, А/1602 дугаар тушаал, захирамж |
| 6. | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, системийн хөгжүүлэлтийг хийх, хэрэгжилтийг зохион байгуулах | НГЗБА, НХБХГ, ДГЗБА | I-IV улиралд | Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.2 дах заалт |
| 7. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах, мод үржүүлгийн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг тогтоох | НЗДТГ, ЗАА, НГЗБА, НБОГ, ДЗДТГ | I-IV улиралд | Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх тухай 58 дугаар зарлигийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хүрээнд Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2021 оны 03 дугаар зөвлөмж, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамж. |
| **Гурав. Хот байгуулалт, газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажил** | | | | |
| 3.1. Хот байгуулалтын чиглэлээр: | | | | |
| 8. | Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын зөрчлийг арилгаж, газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | НГЗБА, НХБХГ | I-IV улиралд | Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, |
| 9. | Авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, барих ажлыг иргэн, хуулийн этгээдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. | НХБХГ, НГЗБА, ДЗДТГ | I-IV улиралд | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх барьж байгуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 175 дугаар тогтоол; |
| 10. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих | НГЗБА, НХБХГ, ХСОАБХЗГ | I-IV улиралд | “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, ЗТБХБ Сайдын 2010 оны 418 дугаар тушаал; |
| 11. | Дүүргийн нутаг дэвсгэрт авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, барих ажлыг иргэн, хуулийн этгээдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | НХБХГ, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх барьж байгуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 175 дугаар тогтоол; |
| 12. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ | I- IV улиралд | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.1.2 дах заалт; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зуслангийн 26 амны ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулахтай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах | | | |
| 13. | Дүүргийн 1-8, 10 дугаар хороодын нутаг дэвсгэр, орон сууцны хороолол дундах зөвшөөрөлгүй автомашины гараашнуудыг буулган газрыг чөлөөлж, чөлөөлөгдсөн газарт олон нийтэд зориулсан ногоон байгууламж, тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийх боломжийг бүрдүүлэх | НГЗБА, НХБХГ, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4 дэх заалт; |
| 14. | Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ногоон бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах. | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ | I- IV улиралд | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8.1.5, 9.1.2 дах заалт; |
| 15.. | Дүүргийн нутаг дэвсгэрт явган зам болон дугуйн зам, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилт, ногоон байгууламжийн газрын байршлын судалгааг гаргаж, холбогдох ажлыг зохион байгуулах | ЗАА, НХБХГ, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд |
| 3.2. Газар зохион байгуулалтын чиглэлээр: | | | | |
| 16. | Хорооны хилийн цэсийн маргааныг холбогдох дээд шатны байгууллагуудаар шийдвэрлүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах | НИТХ, НЗДТГ, НГЗБА, ДИТХ, ДГЗБА | I-IV улиралд | Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, УИХ-ын 1996 оны 24 дүгээр тогтоол; |
| 17. | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх Дамбадаржаа дэд төвийн газар чөлөөлөлтийн ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед газар чөлөөлөх ажилд хамтран оролцох | НЗДТГ, НГЗБА, НХБХГ, АХБ, ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.2.2 дах заалт; |
| 18. | Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах | ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 58.6 “Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна" дах заалт; |
| 19. | Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутаг түүний хамгаалалтын бүсийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх, хяналт тавих | НИТХ, НГЗБА, ДИТХ, ДГЗБА | I-IV улиралд | Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоол; |
| 20. | Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах. | НГЗБА, НБОГ, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн "Хот тосгон бусад суурин газрын мониторингийн 300 цэгт хөрсний бохирдлын судалгааны ажлыг зохион байгуулах" удирдамж |
| 21. | Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулахаар хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь батлагдсан байршлуудад иргэдийн газрыг орон сууцаар солих, газрыг дүйцүүлэн олгох, шинэчлэн зохион байгуулах ажлыг зохион байгуулж холбогдох байгууллагатай хамтарч ажиллах | НГЗБА, НХБХГ, НОСК | I-IV улиралд | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.6.4 дэх заалт; |
| 22. | Газрын зөрчил, маргааныг шийдвэрлэх нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх |
| 23. | Нэгдсэн Үндэсний байгууллагын хүн амын нутагшил суурьшлын хөтөлбөр буюу НҮБ Хабитат байгууллагаас 2024 онд Сүхбаатар дүүргийн гэр хорооллын суурьшлын иргэдийг үерээс хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл. | НЗАА, СБДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд |
| 24. | Нийслэлийн нутаг дэвсгэрт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамрагдсан газар нутгийн судалгааг гарган, цаашид авах арга | НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 58.7 "Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэмжээний талаар санал бэлтгэн, холбогдох шийдвэрийг гаргуулах, чанарын төлөвлөгөөт хянан баталгааг Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Сонгинохайрхан, Налайх, Багануур, Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулах. | | | өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" дах заалт; |
| 25. | Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах, зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах. | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 58.6 "Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна" дах заалт; |
| Дөрөв. Газар өмчлөлийн чиглэлээр хийгдэх ажил | | | | |
| 26. | Газар өмчилсөн иргэдийн шийдвэрийн төсөл бэлтгэх ажлын хэсгийн хурлаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх, кадастрын зурагт өөрчлөлт оруулах асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж шийдвэрлэх | НЗДТГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль", "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах |
| 27. | Улаанбаатар хотын ногоон бүс буюу зуслангийн амнуудад газар эзэмшиж байгаа иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчлүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах | НЗДТГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 101, 181 дүгээр тогтоол, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу |
| 28. | Газар өмчлөх иргэдийн санал, хүсэлтийг цахим системээр хүлээн авах, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх | НЗДТГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 29. | Гамшиг эрсдэлийн болон нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн нийслэлийн гамшгаас хамгаалах газар зохион байгуулах албаны нөөцөөс нийслэлийн иргэдэд өмчлүүлж, эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах | НЗДТГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах |
| 30. | Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо Хайлааст, Хандгайт, Яргайт, Рашаан, Ногооны талбайн байршлуудад холбогдох хууль, журмын дагуу иргэний хүсэлтийг үндэслэн эзэмшиж буй газрыг өмчлүүлэх | НЗДТГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэлийн 9.6 дэх заалт; “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах |
| Тав. Газрын кадастрын чиглэлээр хийгдэх ажил | | | | |
| 31. | Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүс, ойн сан болон усан сангийн хориглолтын бүсүүдэд барилгын норм дүрэм зөрчиж газар эзэмших, ашиглах эрх олгосон дүүргийн Засаг даргын захирамжийг судлан газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох зэрэг холбогдох арга хэмжээг авах | НЗДТГ, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 61.1 “Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно” дэх заалт; |
| 32. | “Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл”-ийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, хугацааг сунгах, талбайн хэлбэр, хэмжээг өөрчлөх асуудлуудыг тухай бүрд нь хэлэлцэж дүүргийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэх | ДЗД, ДГЗБА | I-IV улиралд | Монгол Улсын Газрын тухай хуулийн 37, 38 дугаар зүйл |
| 33. | Дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж газар ашиглалтыг сайжруулах, авто зам болон явган хүний зам | НГЗБА, НХБХГ, ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.2 дах заалт; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | талбайг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах болон тохижилтын ажил гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилгоор газрын зөрчил арилгах, орчны аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг зохион байгуулах | | | |
| 34. | Нийтийн зориулалттай орон сууцны орчны газар ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийж, сууц өмчлөгчдийн холбоодын газар ашиглах эрхийн бүртгэл, баталгаажилтын ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих | НГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн $44^1$дүгээр зүйл. Сууц өмчлөгчдийн холбоонд орчны газрыг ашиглуулах; |
| 35. | Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, авто болон явган хүний зам хааж байрлуулсан хашаа, хайс, түц, объектуудыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлж зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах | НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 56.5 “Зохих зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд багтааж газар чөлөөлөх үүрэгтэй; 57.4. Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна” дэх заалт; |
| 36. | Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний хүрээнд төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалангийн талбайн зориулалтаар эзэмшиж ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн газарт судалгаа хийж зөрчилтэй нэгж талбаруудын газрын эрхийг хүчингүй болгох, мөн төсөл хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, байгууллагад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах. | ХХААХҮЯ НЗДТГ, НХХААГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол |
| | Зургаа. Газрын зураглал, мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэх ажил | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 37. | GNSS-ийн геодезийн байнгын ажиллагаатай станцын хэвийн үйл ажиллагааг хангаж, хяналт тавьж ажиллах. | НГЗБА | I-IV улиралд | Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх; |
| 38. | Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах. | НЗДТГ , НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх; |
| 39. | Иргэн хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем, гар утасны аппликейшнд хөгжүүлэлт хийж газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч хувь хүн, хуулийн этгээдүүд өөрийн газартай холбоотой төрийн үйлчилгээг газрын удирдлагын нэгдсэн цахим системийг ашиглаж хүсэлт гаргах, хамааралтай мэдээ мэдээллийг зохих журмын дагуу түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх. | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Засгийн Газрын 2020 оны 110 дугаар тогтоол; |
| 40. | Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын орон зайн мэдээллийг бүрдүүлж, газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд оруулах. | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Засгийн Газрын 2017 оны 289 дугаар тогтоол; |
| 41. | Нийслэл дэх газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажил болон газар зүйн нэрийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх; |
| 42. | Дүүрэг дэх газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажил | НГЗБА, ДГЗБА, ДЗДТГ | I-IV улиралд | Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх; |
| 43. | НҮБ Хабитат байгууллагаас 2024 онд дүүргийн гэр хорооллын иргэдийг үерээс хамгаалах чадавхыг бэхжүүлэх төслийн байршилд хээрийн судалгаа хийж, хэмжилт, зураглал хийх | ДГЗБА, ДЗДТГ | | Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх; |
| Долоо. Газрын татвар, төлбөр, үнэлгээний чиглэлээр хийгдэх ажил | | | | |
| 44. | Газрын үнэлгээний зэрэглэл (бүс)-ийн газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга, түүнийг хэрэгдэх зааг, хязгаарыг Нийслэлийн иргэдийн | НГЗБА | I-IV улиралд | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах | | | |
| 45. | Газрын кадастрын мэдээллийн системд газар эзэмшигч, ашиглагч нарын бүртгэлийн алдаагүй, үндсэн нэгж талбарын газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэхийг үүсгэх ажлыг зохион байгуулах | НГЗБА | I-IV улиралд | |
| 46. | Засгийн Газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12/39 дүгээр тогтоол шинэчлэгдсэн тохиолдолд газрын үнэлгээний итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг шинэчлэх, дүгнэх, хэрэгжилтийг зохион байгуулах | НЗДТГ, НГЗБА | | |

## ХОЁР. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

| 2.1. Өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д/д | Дүүрэг | Хорo о | Газрын байршил | Иргэд-ийн тоо | Газрын хэмжээ /га/ | Зориулалт | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага |
| 1 | | 12 | Хангайн гудамж | 3 | 0.15 | Гэр бүлийн хэрэгцээнд | I-IV улиралд | НГЗБА, ДГЗБА |
| 2 | | 13 | Рашаан, Ногоон тайлбай | 2 | 0.1 | | | |
| 3 | | 14 | Хандгайтын гудамж | 2 | 0.1 | | | |
| 4 | | 15 | Архутай-1, Дамбадаржаа-4, Ар хустай | 33 | 2 | | | |
| 5 | | 16 | Бэлхийн гудамж | 8 | 0.4 | | | |
| 6 | | 17 | Дамбадаржаа | 5 | 0.3 | | | |
| 7 | | 18 | Бэлхийн гудамж | 17 | 1.02 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Сүхбаатар | 19 | Санзай зуслан, Хандгайт, Хандгайтын богино, Баянбулаг, Майхан толгой, Шарга морьт, Хуурай мухар, Гоодой | 97 | 6 | | | |
| 9 | | 20 | Бэлхийн зуслан, Сэлбэ, Сэлх | 92 | 5.5 | | | |
| Дүн | | | | 259 | 15.57 | | | |

2.2. Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд

| Д/д | Дүүрэг, хороо | Газрын байршил | Зориулалт | Газрын хэмжээ /га/ | Хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сүхбаатар дүүргийн 16, 17 дугаар хороо | Дамбадаржаа орчим | Инженерийн барилга байгууламж | 5.0 | I-IV улиралд | ЗАА, АХБ, ДЗДТГ |
| Дүн | | | | 5.0 | | |

2.2.а Газрын эрхийг хэсэгчлэн болон бүхлээр нь хүчингүй болгох, дуусгавар болсон байршлуудад төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлэх

| Д/д | Дүүрэг, хороо | Газрын байршил | Зориулалт | Газрын хэмжээ /га/ | Хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэрт | Сургууль | 0.8 | I-IV улиралд | НБГ |
| 2. | Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо | Хандгайт зуслан | Ахмадын барилга | 0.61 | I-IV улирал | СБДЗДТГ |
| Дүн | | | | 1.41 | | |

2.3 Нийтийн эдэлбэр газрын байршил, хэмжээг тогтоох

| Д/д | Дүүрэг, хороо | Газрын байршил | Зориулалт | Газрын хэмжээ /га/ | Хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо | 6/3 дугаар байрны баруун болон урд талд | Нийтийн эдэлбэр | 0.0367 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| 2. | Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо | 14/б дугаар байрны баруун урд тал | Нийтийн эдэлбэр | 0.155 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| 3. | Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо | УС-11 дүгээр байрны зүүн урд талд | Нийтийн эдэлбэр | 0.0528 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| 4. | Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо | 19 дүгээр байрны урд талд | Нийтийн эдэлбэр | 0.1887 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| 5. | Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо | Залуучууд зочид буудлын урд талд | Нийтийн эдэлбэр | 0.0179 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| 6. | Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо | 46 дугаар байрны хойд талд | Нийтийн эдэлбэр | 0.0417 | I-IV улиралд | НГЗБА, НХБХГ, ДЗДТГ |
| Дүн | | | | 0.493 | | |

## ГУРАВ. НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

3.1. Барилга байгууламжийн газрыг чөлөөлөх, нөхөх олговортойгоор чөлөөлөх

| Д/д | Дүүрэг, хороо | Газрын байршил | Чөлөөлөх нэгж талбарын тоо | Чөлөөлөх газрын хэмжээ /м2/ | Зориулалт | Хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэрт | - | 0.8 | Сургууль | I-IV улиралд | НБГ, НГЗБА |
| 2. | Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэрт | - | 0.5 | Цэцэрлэг | I-IV улиралд | НБГ, НГЗБА |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Сүхбаатар дүүргийн 9, 11 дүгээр хороо | Алтайн 10, 11, Чингэлтэй 14,15, Нуурын 7 дугаар гудамж орчим | 159 | 0.35 | Үндэсний урлагийн их театр | I-IV улиралд | НГЗБА, СЯ |
| Дүн | | | 159 | 1.65 | | | |

| 3.2 Дэд төвүүдийн газрыг чөлөөлөх | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| № | Дүүрэг, хороо | Газрын байршил | Чөлөөлөх нэгж талбар тоо | Чөлөөлөх газрын хэмжээ /га/ | Зориулалт | Хугацаа | Хариуцах байгууллага |
| 1. | Сүхбаатар дүүргийн 13, 14 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо | Сэлбэ дэд төв | 2003 | 158.0 | Дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтийн барилга, байгууламж | I-IV улиралд | НГЗБА, НХОГ, АХБ |
| 2. | Сүхбаатар дүүргийн 16, 17 дугаар хороо | Дамбадаржаа дэд төв | 217 | 60.0 | Дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга, байгууламж | I-IV улиралд | НГЗБА, НХОГ, АХБ |
| Нийт | | | 2220 | 218 | | | |

| 3.3 Инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн газрыг чөлөөлөх | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| № | Дүүрэг, хороо | Газрын байршил | Чөлөөлөх нэгж талбар тоо | Чөлөөлөх газрын хэмжээ /га/ | Зориулалт | Хугацаа | Хариуцах байгууллага |
| 1. | Сүхбаатар 9,11 дүгээр хороо | Алтайн 10, 11, Чингэлтэй 14,15, Нуурын 7 дугаар гудамж орчим | 58 | 1.5 | Дэнжийн мянга дэд төвийн дулааны цахилгаан станцын ажил | I-IV улиралд | НГЗБА, НХОГ |
| 1. | Сүхбаатар 13 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | - | - | ЖДҮДТөвийн барилгын дулааны шугам | I-IV улиралд | ДЗДТГ, ГЗБА |
| 2. | Сүхбаатар 13 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | - | - | Хорооны байрыг дулааны шугамд холбох | I-IV улиралд | ДЗДТГ, ГЗБА |
| 3. | Сүхбаатар 15 дугаар хороо | Дамбадаржаа 81 дүгээр гудамж орчим | - | - | Төмөр бетон гүүр | I-IV улиралд | ДЗДТГ, ГЗБА |
| 4. | Сүхбаатар 15 дугаар хороо | Хорооны нутаг дэвсгэр | - | - | Хорооны байрыг дулааны шугамд холбох | I-IV улиралд | ДЗДТГ, ГЗБА |
| 3.4. Авто зам, замын байгууламжийн газрыг чөлөөлөх | | | | | | | |
| № | Дүүрэг, хороо | Газрын байршил | Чөлөөлөх нэгж талбар тоо | Чөлөөлөх газрын хэмжээ /га/ | Зориулалт | Хугацаа | Хариуцах байгууллага |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо | Цагдаагийн гудамжны хойд талын босоо тэнхлэгийн авто зам | - | 0.50 | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ |
| 2. | Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо | Цагдаагийн гудамжны хойд талын хэвтээ тэнхлэгийн авто зам | - | 0.87 | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ |
| 3. | Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо | Сэлбэ голын баруун талын авто замаас хойшоо шинээр хийгдэх авто зам, гүүр | - | 0.45 | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ |
| 4. | Сүхбаатар дүүргийн 15, 16 дугаар хороо | Дамбадаржаа 2-3, 13, 20-23 дугаар гудамж, Бэлх 6-7 дугаар гудамж | 56 | 0.26 | Авто зам | 2022-2023 | НГЗБА, НЗХГ |
| 5. | Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг | Шинэ тойрог зам хойд хэсэг багц-3 | 2167 | 70.6 | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ, УБХХК |
| 6. | Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо | Элчингийн гудамжийг Юнескогийн гудамжтай холбох авто зам | 7 | - | Авто зам | I-IV улиралд | БХБЯ, НГЗБА, НЗХГ, ХБХГ, НХБЗТХ |
| 7. | Сүхбаатар дүүргийн 9,10,11 дүгээр хороо | Хүнсний 4 уулзвараас 32-ын тойрог хүртэлх явган зам, дугуйн зам | 28 | 0.916 | Явган зам, дугуйн зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ, НЗДТГ |
| 8. | Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо | Хийморь оффисоос 57 дугаар автобусны буудал хүртэлх | 38 | 2.66 | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ, НЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо | Цагдаагийн гудамжийг УБЦТС Зүүн түгээх төвтэй холбох авто зам | 19 | - | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ |
| 10. | Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо | Худгийн гудамжийг Цагдаагийн гудамжтай холбох авто зам | 15 | - | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ |
| 11. | Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо | Цагдаагийн гудамжнаас Сэлбийн баруун эргийн далан хүртэлх авто зам | 12 | - | Авто зам | I-IV улиралд | ЗТХЯ, НГЗБА |
| 12. | Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо | Цагдаагийн гудамжны хойд талын босоо тэнхлэгийн авто зам | 29 | - | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ |
| 13. | Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо | Хангайн 1 дүгээр гудамжнаас Сэлбийн баруун эргийн далан хүртэлх авто зам | 57 | - | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ, |
| 14. | Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо | Цагдаагийн гудамжны хойд талын хэвтээ тэнхлэгийн авто зам | 64 | - | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ, |
| 15. | Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо | Сэлбэ голын баруун талын авто замаас хойшоо шинээр хийгдэх авто зам, гүүр | 4 | 0.318 | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ, |
| 16. | Сүхбаатар дүүргийн 15,16 дугаар хороо | Дамбадаржаа 2-3, 13, 20-23 дугаар гудамж, Бэлх 6-7 дугаар гудамж | 99 | 2.6 | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17. | Сүхбаатар дүүргийн 15, 19 дүгээр хороо | Шадивлангийн авто замаас Гоодойн авто зам хүртэлх авто зам | 50 | - | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ, СХДЗДТГ |
| 18. | Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо | Гоодойн авто замаас Шаргаморьтын авто замтай холбогдох авто зам | 37 | - | Авто зам | I-IV улиралд | НГЗБА, НЗХГ, СХДЗДТГ |
| Нийт | | | 2682 | 79.174 | | | |

## ДӨРӨВ. ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

| 4.1. Газрын төлбөрийн орлого бүрдүүлэх чиглэлээр | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| № | Дүүрэг | Зориулалт /нэгж талбар бүрийг зориулалтаар нь ангилна/ | Газрын хэмжээ /$м^2$/ | $1м^2$ газарт ногдуулах төлбөрийн хэмжээ /төг/ | Татвар тооцох хугацаа | Нийт төвлөрүүлэх төлбөрийн хэмжээ /мян.төг/ | Хариуцах байгууллага |
| 1. | Сүхбаатар дүүрэг | Иргэний ахуйн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газар 4077 | 15519591 | 48 | Жилдээ | 464924 | |
| 2. | | Төсөвт байгууллага 829 | 68715 | 141 | | 12004.8 | |
| 3. | | Нийтийн зориулалттай орон сууц 1407 | 1879662 | 174 | | 501545.6 | |
| 4. | | Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ 10216 | 126364 | 358 | | 104864.7 | |
| 5. | | Нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц 311 | 3978 | 358 | | 4074.5 | |
| 6. | | Бүх төрлийн гарааш /газар дээрх, доорх/ 128 | 1167 | 358 | | 536.6 | |
| 7. | | Нийтийн эдэлбэрийн газар 28 | 0 | 0 | | 0 | |
| 8. | | Инженерийн шугам сүлжээ түүний дэд бүтэц байгууламж 276 | 6307 | 70 | | 765.3 | |
| 9. | | Төмөр зам, нисэх онгоцны буудал 13 | 0 | 0 | | 0 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10. | | Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар 19 | 0 | 0 | | 0 | Дүүргийн татварын хэлтэс, ДГЗБА |
| 11. | | Шашин, сүм, хийд 101 | 11687 | 476 | | 7178.1 | |
| 12. | | Химийн хорт бодис арьс шир ноос ноолуурын үйлдвэр, цэвэрлэх байгууламж болон аюултай хог хаягдлын үйлдвэр 10 | 0 | 0 | | 0 | |
| 13. | | Бүх төрлийн үйлдвэрлэл /хөдөө аж ахуйгаас бусад/ 1821 | 33681 | 1152 | | 17730.8 | |
| 14. | | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 1947 | 560414 | 96 | | 38874.0 | |
| 15. | | Уурхайн эдэлбэр газар | - | - | | 0 | |
| 16. | | Хөдөө аж ахуйн газар /тариалан, хадлан, бэлчээр/ 98 | - | - | | 0 | |
| 17. | | Бусдаас /Сангийн яамнаас гаргасан төсвийн төлөвлөгөөний зөрүү/ | - | - | | 0 | |
| Нийт | | | 3280121 | | | 900000.0 | |

--o0o--